

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
3. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ӨМӨЗО	Өвөр Монголын Өөртөө Засах Орон



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.БАЙГАЛСАЙХАН ТАНАА

2020.03.13 № 06/825
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатарын их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улаанбаатарын их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улаанбаатарын их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Улаанбаатарын их сургууль нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Улаанбаатарын их сургуулийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус сургуулийн захирал С.Байгалсайхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн анхан шатны баримтын бүрдүүлэлтэд хяналт тавих, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, программ хангамжийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатарын их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Улаанбаатарын их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Улаанбаатарын их сургуулийн удирдлага нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль дагуу болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 05-наас 2020 оны 3 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Монголиан Бизнес Рейтинг Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Улаанбаатарын их сургуулийн 2019 оны санхүүгийн тайланг “Монголиан Бизнес Рейтинг Аудит” ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 1/028 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Улаанбаатарын их сургууль үйл ажиллагааны зорилгоо “Эрдэмтэн багш нарын нөөц бололцоо, сургалтын материаллаг баазад түшиглэн шинжлэх ухаан үйлдвэрлэл, нийгмийн бүхий л салбарт бие даан ажиллах чадвартай, хувь хүний хөгжил, харилцааны өндөр соёлтой мэргэжлийн боловсон хүчнийг өөрийн болон өндөр хөгжилтэй орнуудын жишигт нийцүүлэн бэлтгэх, сургалт, судалгаа, үйлдвэрлэлийн цогц бодлого бүхий сургуулийн үйл ажиллагааг тасралтгүй хөгжүүлэх” гэж тодорхойлсон.

Улаанбаатарын их сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дээд боловсрол эзэмшүүлэх мэргэжил, сургалтын чиглэл, төвшин бүрээр зохих стандартыг үндэслэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явуулна гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд татварын хөнгөлөлт
- Нийгмийн даатгалын тухай хуульд шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орсныг хэрэгжүүлж ажилласан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Улаанбаатарын их сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Улаанбаатарын их сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Повер Софт” ХХК-ийн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн “Powersoft 4.0” программ хангамж ашигладаг байна.

Улаанбаатарын их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Улаанбаатарын их сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 16 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,069.5 сая төгрөгөөс тооцон материаллаг байдлын түвшнийг 41.4 сая төгрөгөөр тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 37.9 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны санхүүгийн тайлангийн сонгосон суурь үзүүлэлтээс тооцоолсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Улаанбаатарын их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 79.9 сая төгрөгөөр буюу 1.0 хувиар өссөн байна. Оны эхний болон эцсийн үзүүлэлтийг харьцуулахад мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /сая төгрөг/
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	427.5	523.9	96.4
Авлага	42.1	69.5	27.4
Бараа материал	8.7	8.9	0.2
Үндсэн хөрөнгө	7,693.8	7,649.7	-44.1
Нийт хөрөнгө	8,172.1	8,252.0	79.9
Өр төлбөр	62.9	168.0	105.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8,109.2	8,084.0	-25.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,172.1	8,252.0	79.9

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 96.4 сая төгрөгөөр өссөн нь БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлсэн археологийн хайгуулын ажлын үр дүнд үнэт, хосгүй олдворуудыг олж Монголбанкны эрдэнэсийн санд хүлээлгэн өгч, олдворыг сэргээн засах ажлын зардалд 250.0 сая төгрөгийг Монголбанкнаас олгосноос шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 27.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд оюутнууд сургалтын төлбөрөө төлөөгүйгээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд өмнөх онуудад үүссэн, он удаан жил болсон барагдах боломжгүй, эрсдэлтэй авлага байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 44.1 сая төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 246 дугаар тогтоолоор 13.1 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмжийг акталснаас шалтгаалжээ. Өөрийн болон төслийн хөрөнгө оруулалтаар 42.5 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж, 12.6 сая төгрөгийн тавилга эд хогшил, 0.6 сая төгрөгийн ном, нийт 55.7 сая төгрөгийн хөрөнгө худалдаж авсан байна.

Өр төлбөр буюу урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 105.1 сая төгрөгөөр өссөн нь оюутнууд 2019-2020 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийг урьдчилж төлснөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,084.0 сая төгрөг болж, 25.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Улаанбаатарын их сургуулийн 2019 оны төсвийг Удирдах зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор тодотгож баталсан байна.

Тайлант онд байгууллагын үйл ажиллагаанд зориулан 1,809.0 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж, нийт зардлын 35.0 сая төгрөгийг эрдэм шинжилгээний төсөл хөтөлбөрөөс, 1,135.2 сая төгрөгийг сургалтын төлбөрийн орлогоос, 638.8 сая төгрөгийг үйл ажиллагааны бус орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд нийт орлого төлөвлөгөөнөөс 3.3 хувиар буюу 60.1 сая төгрөгөөр давж биелсэн нь сургалтын төлбөрийн орлого 31.4 сая төгрөгөөр, эрдэм шинжилгээний гэрээт ажил, төслийн орлого 28.4 сая төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Нийт зардалд 1,809.0 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,869.1 сая төгрөгийг зарцуулж, 60.1 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Энэ нь тус сургуулийн Удирдах зөвлөлийн баталсан 2019 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөнд батлагдаагүй, Европын холбоотой хамтран хэрэгжүүлсэн “Arrow” төслөөс 2019 оны 12 дугаар сард 60.1 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, 60.1 сая төгрөгийн төслийн зарцуулалт гарснаас шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 16 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 16 эрсдэл тодорхойлж нийт 16 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 55.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 27.0 сая төгрөгийн алдааг залруулж, 1 албан шаардлага хүргүүлж, 28.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим системд 9 мэдээллийг хугацаа хоцроож, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг байршуулаагүй буюу өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ: 6.1.1. тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, ... жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор...” заалттай нийцэхгүй, хэмжилт, үнэн зөв байдал, үнэлгээ, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 28.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Улаанбаатарын их сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Улаанбаатарын их сургууль нь шилэн дансны нэгдсэн системд 3 чиглэлийн 18 мэдээллийг байршуулахаас 7 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг огт байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 12.4 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосноос бүрэн барагдуулсан байна.

Нийт 6 зөвлөмж өгснөөс 5 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу Шилэн дансны нэгдсэн цахим системд 9 мэдээллийг хугацаа хоцроож, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг огт байршуулаагүй байна. Зөвлөмжийн хэрэгжилт 83.3 хувьтай байна

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улаанбаатарын их сургуулийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Улаанбаатарын их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой

3.1.1 Илрүүлэлт:

Цаасан болон цахим анхан шатны баримтын бүрдэлгүй 28.1 сая төгрөгийн зарцуулалт гаргасан байна. Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдэлтэй нийцээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.”, 20 дугаар зүйлийн 20.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна: 20.1.4 хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” заалтуудыг зөрчсөн.

3.1.2 Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэж, тайлагнах.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулах. Бэлтгэн нийлүүлэгчдийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг албан бичгээр ирүүлсэн.

3.2 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.2.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, хууль тогтоомж, заавар, журмын дагуу шинэчлэгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдэлтэй нийцээгүй, заалтыг зөрчсөн.

3.2.2 Эрсдэл:

Хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан заавар, журам зөрчигдөх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт хууль тогтоомж, заавар, журамд нийцүүлэн шинэчилж байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг албан бичгээр ирүүлсэн.

3.3 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.3.1 Илрүүлэлт:

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамж нь санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны гүйцэтгэлийг илчилж, толилуулаагүй, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг цахим тайлангийн нэгтгэлд татан оруулах, санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг төлөвлөгөөтэй харьцуулж, шинжилгээ хийх боломжгүй байна. Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдэл, Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-тай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Тайлан мэдээ хугацаа алдаж гарах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн программд шаардлагатай шинэчлэлтийг хийлгүүлж байх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг албан бичгээр ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	478,259,054.20	602,320,713.09
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	427,465,920.36	523,875,865.25
312	Банканд байгаа бэлэн мөнгө	427,465,920.36	523,875,865.25
3121	Төгрөг	410,717,165.03	493,191,315.14
31213	Арилжааны банк дахь харилцах	410,717,165.03	493,191,315.14
31220	Гадаад валют	16,748,755.33	30,684,550.11
31223	Арилжааны банк дахь харилцах	16,748,755.33	30,684,550.11
33	АВЛАГА	42,067,884.00	69,506,798.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	42,067,884.00	69,506,798.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8,725,249.84	8,938,049.84
354	Хангамжийн материал	8,725,249.84	8,938,049.84
35420	Аж ахуйн материал	3,005,249.84	3,218,049.84
35470	Бусад хангамжийн материал	5,720,000.00	5,720,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,693,854,014.14	7,649,683,747.08
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,693,854,014.14	7,649,683,747.08
392	Биет хөрөнгө	7,346,351,854.14	7,302,181,587.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,091,444,842.00	7,091,444,842.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(73,690,358.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	307,676,157.68	337,057,697.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	-242,198,265.53	(243,479,436.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	242,994,450.98	255,646,760.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	-189,924,967.57	(200,298,753.61)
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,665,000.18	19,665,000.18
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,540,000.60	(2,984,300.92)
39217	Ном	118,234,637.00	118,820,137.00
393	Биет бус хөрөнгө	347,502,160.00	347,502,160.00
39301	Программ хангамж	1,670,000.00	1,670,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,670,000.00	(1,670,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	347,502,160.00	347,502,160.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,172,113,068.34	8,252,004,460.17
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	62,921,613.30	167,985,409.10
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	62,921,613.30	167,985,409.10
414	Урьдчилж орсон орлого	62,921,613.30	167,985,409.10
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	62,921,613.30	167,985,409.10
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,109,191,455.04	8,084,019,051.07
51	Засгийн газрын хувь оролцоо	8,109,191,455.04	8,084,019,051.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,352,370,591.00	2,352,370,591.00
51101	Өмч: - төрийн	2,352,370,591.00	2,352,370,591.00
512	Хуримтлагдсан үр дүн	50,594,176.83	25,421,772.86
51210	Өмнөх үеийн үр дүн	-28,756,196.42	50,594,176.83
51220	Тайлант үеийн үр дүн	79,350,373.25	(25,172,403.97)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,706,226,687.21	5,706,226,687.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН I=IV+V	8,172,113,068.34	8,252,004,460.17

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,148,823,154.29	1,869,149,389.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,984,564,509.29	1,634,759,339.28
120	Нийтлэг татварын бус орлого	1,984,564,509.29	1,634,759,339.28
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,984,564,509.29	1,634,759,339.28
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	943,177,976.00	932,249,984.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,036,950,398.29	702,509,355.28
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	4,436,135.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	164,258,645.00	234,390,050.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	124,258,645.00	234,390,050.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	124,258,645.00	234,390,050.00
1330	Төсвийн захирагчдаас	40,000,000.00	-
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	40,000,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,069,472,781.04	1,894,321,793.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,069,472,781.04	1,894,321,793.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,064,735,468.50	1,893,121,793.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	857,488,182.82	925,344,692.43
210101	Үндсэн цалин	857,488,182.82	925,344,692.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,734,038.70	107,731,026.55
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	98,734,038.70	107,731,026.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,343,291.82	69,794,104.57
210301	Гэрэл, цахилгаан	16,077,290.00	17,958,982.00
210302	Түлш, халаалт	30,474,494.53	33,661,554.32
210303	Цэвэр, бохир ус	8,791,507.29	18,173,568.25
2104	Хангамж, бараа материалын зардал	13,345,111.20	29,239,053.65
210401	Бичиг хэрэг	1,030,700.00	16,320,131.21
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,425,733.20	10,164,000.44
210404	Ном, хэвлэл	3,888,678.00	2,754,922.00
2105	Нормативт зардал	519,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	519,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	53,975,783.00	4,902,500.00
210604	Урсгал засвар	53,975,783.00	4,902,500.00
2107	Томилолт, зочны зардал	8,420,800.00	6,010,970.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	8,420,800.00	6,010,970.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,424,274.60	52,159,766.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,279,024.00	51,672,205.11
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	145,250.60	487,561.43
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	962,484,986.36	697,939,679.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	837,707,018.50	512,465,551.67
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	33,059,766.16	85,542,472.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	91,718,201.70	99,931,655.84

Улаанбаатарын их сургуулийн 2019 оны
санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,737,312.54	1,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,737,312.54	1,200,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,370,492.54	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	366,820.00	1,200,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>79,350,373.25</u>	<u>-25,172,403.97</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>79,350,373.25</u>	<u>-25,172,403.97</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,933,830,589.54	2,048,971,625.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,769,571,944.54	1,814,581,575.89
120	Нийтлэг татварын бус орлого	1,769,571,944.54	1,814,581,575.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,769,571,944.54	1,814,581,575.89
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	956,451,513.00	912,083,512.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	813,120,431.54	902,498,063.89
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	164,258,645.00	234,390,050.00
1320	Улсын төвлөрсөн төсвөөс	124,258,645.00	234,390,050.00
131007	Засгийн гарын тусгай сангаас санхүүжих	124,258,645.00	234,390,050.00
1330	Төсвийн захирагчдаас	40,000,000.00	-
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	40,000,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,863,153,060.57	1,896,800,292.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,863,153,060.57	1,896,800,292.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,859,918,060.57	1,892,561,792.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	796,307,562.03	804,127,561.35
210101	Үндсэн цалин	796,307,562.03	804,127,561.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	171,460,706.19	244,132,989.44
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	171,460,706.19	244,132,989.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,257,691.82	69,794,104.57
210301	Гэрэл, цахилгаан	16,077,290.00	17,958,982.00
210302	Түлш, халаалт	30,474,494.53	33,661,554.32
210303	Цэвэр, бохир ус	8,791,507.29	18,173,568.25
210304	Байрны түрээс	1,914,400.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	13,471,011.20	14,897,482.44
210401	Бичиг хэрэг	941,400.00	1,978,560.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,785,733.20	10,164,000.44
210404	Ном, хэвлэл	3,743,878.00	2,754,922.00
2105	Нормативт зардал	558,800.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	558,800.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	184,322,583.00	4,640,500.00
210604	Урсгал засвар	184,322,583.00	4,640,500.00
2107	Томилолт, зочны зардал	13,510,400.00	6,010,970.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	13,510,400.00	6,010,970.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,601,094.60	82,323,030.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,125,844.00	65,254,410.24
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	145,250.60	489,566.54
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	330,000.00	16,579,054.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	608,428,211.73	666,635,153.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	572,783,270.73	569,508,413.64
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	35,644,941.00	97,126,740.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,235,000.00	4,238,500.00

Улаанбаатарын их сургуулийн 2019 оны
санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	3,235,000.00	4,238,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,235,000.00	4,238,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>70,677,528.97</u>	<u>152,171,333.67</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,611,192.68	55,761,388.78
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,611,192.68	55,761,388.78
2200	Дотоод эх үүсвэрээр	14,611,192.68	55,761,388.78
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,611,192.68	55,761,388.78
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-14,611,192.68</u>	<u>-55,761,388.78</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	56,066,336.29	96,409,944.89
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	371,399,584.07	427,465,920.36
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	427,465,920.36	523,875,865.25

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,004,868,431.00	660,700,351.00	-28,756,196.42	2,636,812,585.58
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,004,868,431.00	660,700,351.00	-28,756,196.42	2,636,812,585.58
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	5,045,526,336.21	-	5,045,526,336.21
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	347,502,160.00	-	-	347,502,160.00
Тайлант үеийн үр дүн	-	-	79,350,373.25	79,350,373.25
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,352,370,591.00	5,706,226,687.21	50,594,176.83	8,109,191,455.04
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-25,172,403.97	-25,172,403.97
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,352,370,591.00	5,706,226,687.21	25,421,772.86	8,084,019,051.07

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	2019 оны төсөв	2019 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлогын дүн	1,808,992,042.00	1,869,149,389.28	(60,157,347.28)	(103.3)
Үндсэн үйл ажиллагааны орлого	1,170,152,200.00	1,201,577,142.00	(31,424,942.00)	(102.7)
Төсвийн санхүүжилт	34,946,700.00	34,937,000.00	9,700.00	(100.0)
ЭШ-ний төсөл, хөтөлбөр	34,946,700.00	34,937,000.00	9,700.00	(100.0)
Тогтмол зардлын санхүүжилт	-	-	-	-
Сургалтын төлбөрийн орлого	1,135,205,500.00	1,166,640,142.00	(31,434,642.00)	(102.8)
Бакалаврын сургалтын	882,043,500.00	932,249,984.00	(50,206,484.00)	(105.7)
Магистрын сургалтын	179,818,000.00	158,922,658.00	20,895,342.00	(88.4)
Докторын сургалтын	44,344,000.00	38,272,400.00	6,071,600.00	(86.3)
Гадаад оюутны	29,000,000.00	37,195,100.00	(8,195,100.00)	(128.3)
Үйл ажиллагааны бус орлого	638,839,842.00	667,572,519.26	(28,732,677.26)	(104.5)
ЭШ-ний гэрээт ажил, төслийн орлого	567,839,842.00	588,919,971.35	(21,080,129.35)	(103.7)
Харилцахын хүүгийн орлого	6,000,000.00	8,524,947.91	(2,524,947.91)	(142.1)
Хураамж, бусад	65,000,000.00	70,127,600.00	(5,127,600.00)	(107.9)
Нийт зарлагын дүн	1,808,992,042.00	1,869,149,389.28	(60,157,347.28)	(103.3)
Цалин хөлсний зардал	1,027,239,242.00	1,033,075,718.98	(5,836,476.98)	(100.6)
Цалин хөлс. нэмэгдэл урамшуулал	921,290,800.00	925,344,692.43	(4,053,892.43)	(100.4)
НДШ	105,948,442.00	107,731,026.55	(1,782,584.55)	(101.7)
Бараа үйлчилгээний нийтлэг зардал	106,494,500.00	94,075,969.00	12,418,531.00	(88.3)
Бичиг хэргийн зардал /захиргаа/	3,000,000.00	1,978,560.00	1,021,440.00	(66.0)
Аж ахуйн зардал	6,500,000.00	3,515,400.00	2,984,600.00	(54.1)
Шуудан холбооны зардал	3,850,000.00	2,546,685.00	1,303,315.00	(66.1)
Шагналын зардал	3,500,000.00	3,083,500.00	416,500.00	(88.1)
Гадаад арга хэмжээний зардал	6,000,000.00	6,010,970.00	(10,970.00)	(100.2)
Тусламж тэтгэлгийн зардал	10,000,000.00	7,964,000.00	2,036,000.00	(79.6)
Урсгал засварын зардал	7,000,000.00	4,902,500.00	2,097,500.00	(70.0)
Төлбөр хураамжийн зардал	45,000,000.00	44,906,200.00	93,800.00	(99.8)
Хэвлэл мэдээллийн зардал	10,000,000.00	16,579,054.00	(6,579,054.00)	(165.8)
Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зардал	11,644,500.00	2,589,100.00	9,055,400.00	(22.2)
Сургалтын үйлчилгээний зардал	131,500,000.00	114,882,408.64	16,617,591.36	(87.4)
Тогтмол хэвлэлийн зардал	4,000,000.00	2,754,922.00	1,245,078.00	(68.9)
Хичээл практикийн зардал	90,000,000.00	85,542,472.00	4,457,528.00	(95.0)
Интернэтийн зардал	8,500,000.00	7,617,314.64	882,685.36	(89.6)
Оюутны үйлчилгээний зардал	10,000,000.00	7,858,600.00	2,141,400.00	(78.6)
Уралдаан тэмцээний зардал	5,500,000.00	4,850,000.00	650,000.00	(88.2)
Мэргэжлийн олимпиадын зардал	2,500,000.00	240,000.00	2,260,000.00	(9.6)
Гадаад багшийн зардал	1,000,000.00	128,500.00	871,500.00	(12.9)
Багшийг дэмжих ҮА-ны зардал	10,000,000.00	5,890,600.00	4,109,400.00	(58.9)

Улаанбаатарын их сургуулийн 2019 оны
санхүүгийн тайлангийн аудит

Эрдэм шинжилгээ. инновацын зардал	455,000,000.00	501,559,569.50	(46,559,569.50)	(110.2)
Эрдэм шинжилгээ	450,000,000.00	496,609,569.50	(46,609,569.50)	(110.4)
Удирдах зөвлөлийн зардал	5,000,000.00	4,950,000.00	50,000.00	(99.0)
Тогтмол зардал	76,758,300.00	69,794,104.57	6,964,195.43	(90.9)
Гэрэл цахилгаан	20,000,000.00	17,958,982.00	2,041,018.00	(89.8)
Халаалтын зардал	38,758,300.00	33,661,554.32	5,096,745.68	(86.8)
Цэвэр бохир усны зардал	18,000,000.00	18,173,568.25	(173,568.25)	(101.0)
Хөрөнгийн зардал	12,000,000.00	55,761,388.78	(43,761,388.78)	(464.7)
ТТ худалдан авах зардал	6,000,000.00	42,523,579.54	(36,523,579.54)	(708.7)
Тавилга эд хогшил худалдан авах зардал	5,000,000.00	12,652,309.24	(7,652,309.24)	(253.0)
Ном сурах бичгийн зардал	1,000,000.00	585,500.00	414,500.00	(58.6)

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.12.31	Аудитын нэр: Улаанбаатарын их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2020/71/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: Улаанбаатарын их сургууль	сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны нэгдсэн цахим системд 9 мэдээллийг хугацаа хоцроож, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг байршуулаагүй буюу өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	-	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	С.Байгалсайхан О.Туяа
2	Цаасан болон цахим анхан шатны баримтын бүрдэлгүй 28.1 сая төгрөгийн зарцуулалт гаргасан байна.	28.1	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	С.Байгалсайхан О.Туяа
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, хууль тогтоомж, заавар, журмын дагуу шинэчлэгдээгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	С.Байгалсайхан О.Туяа
4	Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамж нь санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны гүйцэтгэлийг илчилж, толилуулаагүй, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг цахим тайлангийн нэгтгэлд татан оруулах, санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг төлөвлөгөөтэй харьцуулж, шинжилгээ хийх боломжгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	С.Байгалсайхан О.Туяа
	Нийт	28.1			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 18

№ 02/139

Улаанбаатар хот

СНТ- 2020/71/ СТД-ТӨЧГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатарын их сургуулийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим системд 9 мэдээллийг хугацаа хоцроож, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг огт байршуулаагүй буюу өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ: 6.1.1. тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, ... жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д “...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, холбогдох мэдээллийг хугацаанд нь цахим хуудсанд тогтмол мэдээлж байх, зөрчлийг давтан гаргахгүй анхаарч ажиллах.
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улаанбаатарын их сургуулийн захирал С.Байгалсайхан, нягтлан бодогч О.Туяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *Ц.Наранчимэг*

АУДИТОР *Б.Энхжин* **Б.ЭНХЖИН**

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
"МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ
АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Р.Цанжидмаа **Р.ЦАНЖИДМАА**


ЗӨВШӨӨРСӨН:

УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ *С.Байгалсайхан*

С.БАЙГАЛСАЙХАН

НЯГТЛАН БОДОГЧ

О.Туяа **О.ТУЯА**



Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

ТЭМДЭГЛЭЛ

A series of 25 horizontal dotted lines for writing.